

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЕНТЛАГ (ЖАЙКА)
МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ

МОНГОЛ УЛС

ГОВИЙН БҮСИЙН ДОРНОГОВЬ, ДУНДГОВЬ, ӨМНӨГОВЬ АЙМГУУДЫН БЭЛЧЭЭРИЙН МАЛ АЖ АХУЙН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ СУДАЛГАА

Эцсийн тайлан

2006 ОНЫ 3 САР

JICA LIBRARY



1182188 [1]

ПАСИФИК КОНСАЛТАНТС ИНТЕРНЕСНЛ ХК
МЕТАЛЛ БОЛОВСРУУЛАЛТ, ИНЖЕНЕРИЙН “МИЦУЙ” ХК

R D

JR

06-32

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЕНТЛАГ (ЖАЙКА)
МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ

МОНГОЛ УЛС

ГОВИЙН БҮСИЙН ДОРНОГОВЬ, ДУНДГОВЬ, ӨМНӨГОВЬ АЙМГУУДЫН БЭЛЧЭЭРИЙН МАЛ АЖ АХУЙН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ СУДАЛГАА

Эцсийн тайлан

2006 ОНЫ 3 САР

ПАСИФИК КОНСАЛТАНТС ИНТЕРНЭШНЛ ХК
МЕТАЛЛ БОЛОВСРУУЛАЛТ, ИНЖЕНЕРИЙН “МИЦУЙ” ХК



1182188 [1]

Валютын ханш (2006 оны 1-р сарын байдлаар)		
Ам.доллар 1.00	=	Япон иен 119.07
Төгрөг 1,000	=	Япон иен 97

УДИРТГАЛ

Япон Улсын Засгийн газар Монгол Улсын Засгийн газрын хүсэлтийн дагуу "Говийн бүсийн Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын бэлчээрийн аж ахуйн тогтолцоог сайжруулах төлөвлөгөө"-г боловсруулахаар шийдвэрлэж судалгааны ажлыг хийж гүйцэтгүүлэхээр Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-ыг томилсон юм.

ЖАЙКА нь Пасифик Консалтантс Интэрнэшнэл, Металл Боловсруулалт, Инженерийн "Мицүй" ХК кампаниудыг сонгож Такаши Фужитагаар удирдуулсан судалгааны багийг 2003 оны 3 дугаар сараас 2006 оны 1 дүгээр сарын хооронд томилж явуулсан болно.

Тус баг нь Монголын Засгийн газрын холбогдох албаны хүмүүстэй уулзаж ярилцан судалгааг газар дээр нь явуулсан бөгөөд Японд буцаж ирсний дараа ч судалгааны ажлаа үргэлжлүүлж энэхүү тайланг боловсруулсан болно.

Уг тайлан тус төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд, мөн манай хоёр орны найрсаг харилцааг улам бүр өргөжүүлэхэд хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

Судалгааны багтай нягт уялдаатай, үргэлж хамтран ажиллаж дэмжлэг үзүүлсэн Монголын Засгийн газрын холбогдох албаны хүмүүст гүн талархаснаа илэрхийлж байна.

2006 оны 3 дугаар сар

АРИЮУКИ МАЦУМОТО

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГЫН
ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГЫН
ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ
НОЁН АРИЮУКИ МАЦУМОТО ТАНАА

ӨРГӨН БАРИХ ЗАХИДАЛ

"Монгол Улс Говийн бүсийн Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын бэлчээрийн аж ахуйн тогтолцоог сайжруулах төлөвлөгөө"-ний эцсийн тайланг үүгээр албан ёсоор өргөн барьж байгаадаа бид баяртай байна.

Энэхүү тайлан нь Японы Засгийн газрын холбогдох яам, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага, мөн түүнчлэн Монголын талын багийн гишүүдээс төлөвлөгөөний талаар гаргасан санал, зөвлөмжийн дагуу боловсруулсан "Мастер Төлөвлөгөө"-г багтааж байгаа болно.

Судалгааны бүс нутаг нь Монгол орны өмнөд хэсэг болох говь, хээрийн бүсийн Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийг тус тус хамрах бөгөөд бэлчээр, усны нөөц хомс тус бүс нутагт нүүдлийн мал аж ахуйг эртнээс эрхлэж иржээ. 1990 онд Монгол орон мал аж ахуйн нөхцөл байдлыг эрс өөрчилсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн. Гэсэн хэдий ч тус салбар байгаль, цаг уурын өөрчлөлтөнд өртөх нь их байна. Тухайлбал 1999-2001 онд олон тооны мал хорогдож, ядуу малчин өрхийн тоо нэмэгдсэн. Үүний улмаас ашиглагдахгүй болон бага ашигладаг бэлчээрийн талбай өргөжин, хязгаарлагдмал усны нөөц бүхий худаг, уст цэгийн ойролцоо мал олноор бөөгнөрөх болжээ. Иймээс бэлчээрийг оновчтой ашиглах явдал нь тулгамдсан асуудал болоод байна. Энэхүү Мастер Төлөвлөгөөг Дорноговь аймгийн өмнөд хэсгийн 3 сумын нутагт хоёр жилийн турш явуулсан худаг байгуулалтын туршилтын судалгааны үр дүнг үндэслэн боловсруулав. Тус тайланд санал болгосон "Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт" төсөл нь Монгол оронд цаашид ижил төрлийн төслийг хэрэгжүүлэхэд чиглэл баримжаа болно хэмээн найдаж байна.

Хөдөөгийн мал аж ахуйн тогтолцоог сайжруулахад зөвхөн "Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежмент" төдийгүй "Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулах", "Малчин өрхийн орлогыг тогтворжуулах", "Хүний нөөцийг хөгжүүлэх" нь чухал. Иймээс эдгээр асуудлуудыг хамарсан туршилтын төслүүдийг холбогдох сумдад хэрэгжүүлж судалгааны үр дүнг тус тайланд багтаасан болно. Мөн ийм чиглэлийн төслийг хийж гүйцэтгэхийг сумдын Засаг Даргын Тамгын газруудад санал болгосон. Энэхүү төслийн саналыг сумын Засаг Даргын Тамгын газрууд үр бүтээлтэй хэрэгжүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү боломжийг ашиглан бидний судалгааны ажилд үнэтэй зөвлөмж өгсөн Япон Улсын Хөдөө Аж Ахуй, Ой, Загасны Аж Ахуйн Яам, Гадаад Хэргийн Яам болон танай байгууллагын холбогдох албаны хүмүүст гүнээ баярлан талархаж буйгаа илэрхийлж байна. Мөн түүнчлэн Монгол Улсын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яам, Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн Засаг Даргын Тамгын Газар, Дорноговь аймгийн Эрдэнэ, Улаанбадрах, Хөвсгөл сумын Засаг Даргын Тамгын Газрын холбогдох ажилтнуудад гүн талархал илэрхийлье.

Гүнээ хүндэтгэсэн

Такаши ФУЖИТА

Монгол Улс Говийн бүсийн Дорноговь,
Дундговь, Өмнөговь аймгуудын
бэлчээрийн аж ахуйн тогтолцоог
сайжруулах төлөвлөгөө боловсруулах
Судалгааны багийн Удирдагч




Зудын хохирол

1999-2000 онуудад 2 жил дараалан тохиосон зудын улмаас улсын хэмжээгээр нийт малын 20 орчим хувь буюу 5,750,000 толгой мал хорогдсон байна. Зудад мал хорогдох шалтгаан нь осгох буюу өлсөж үрэгдэх явдал байдаг.



Эвдэрч гэмтсэн худаг

Эвдэрч гэмтсэн худаг эзэнгүй орхигдож худаг ус хүрэлцэхгүй болсон тул одоо байгаа худгуудын эргэн тойрон болон байнгын ашиглалтад байдаг газруудын ойр орчимд малын бөөгнөрөл үүсч бэлчээр талхлагдаж байна.



Мал усалгааны байдал

Зуны ган гачиг, өвлийн их цас зэрэг байгалийн хүчин зүйлтэй хавсран бэлчээрийн талхагдал, худгийн ашиглалт хамгаалалт муудсан, уст цэг хүрэлцэхгүй болсон, тэжээл бэлтгэлийн тогтолцооны хүчин чадал доройтсон зэрэг нийгмийн олон талт хүчин зүйлс уялдан нөлөөлж, зудын хохирлыг үүсгэж байна.




Нүүдлийн мал сүрэг

Говийн бүс нутгийн мал аж ахуйн оршин тогтнох хэлбэр нь бэлчээрийн мал аж ахуй юм. Хонь, ямаа, үхэр, адуу, тэмээ гэсэн 5 хошуу мал бий. Зах зээлийн эдийн засагт шилжсэнээр мал хувьчлагдаж, ажилгүй бологсдын олонхи нь энэ салбарт ажиллаж амь зуух болсон.



Бэлчээрийн байдал

Бэлчээрийн МАА-н оршин тогтнох суурь дэвсгэр нь бэлчээр бөгөөд бэлчээрт уст цэг зайлшгүй байх шаардлагатай. Уст цэггүй бэлчээрийн ашиглалтын үнэ цэнэ бага. Мөн, говийн бүс нутаг нь хагас хуурайшилттай, ургамалжилтын чадавхи багатай нутаг юм.




Монгол улсын Хүнс хөдөө аж ахуйн яам

Нийт 85 ажилтантай, жилийн төсөв 10 тэрбум, 500 сая төгрөг (2005 оны байдлаар 10 тэрбум орчим иен). Монгол улсын эдийн засгийн суурь болсон МАА, хүнсний үйлдвэрлэлтэй холбоотой бодлого боловсруулах, эдгээр салбарт явуулах үйл ажиллагааны асуудлыг хариуцдаг.




Гүний худаг ба түүний ойр орчмын бэлчээрийн байдал

Бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын менежментийн төслөөр 5 газарт шинээр худаг барьж, нийт 17 газарт худаг сэргээн засварлах ажил хийгдлээ.
(Зураг дээр: Эрдэнэ сумын Бутын хоолойн худаг)



Мотор ба ус өргөх насос

Гүний худагт мотор (КАМА) болон усан дотор байрлуулах насос (Grundfos), бусад тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан. Эдгээр тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, хамгаалалтыг малчдын бүлэг хариуцан явуулж байна.



Дорноговь аймаг дээрх сургалт

Уг судалгааны хүрээнд төслийн үйл ажиллагааны менежмент (PCM)-ийн аргыг ашиглан биечлэн оролцох хэлбэрийн төлөвлөгөө, санал боловсруулах ажлыг хэрэгжүүллээ. (2003 оны 8 сар)



Сумын захиргаан дээрх сургалт

Сумын ЗДТГ-ын ажилтнууд, сумын иргэд, малчдыг оролцуулсан төслийн үйл ажиллагааны менежмент (PCM Workshop)-ийн сургалтыг зохион байгууллаа.
(Зураг дээр: Улаанбадрах суманд, 2003 оны 9 сар)



Малжуулах сангийн төслөөр шилмэл омгийн мал нийлүүлэгдсэн тухай

Төслөөр нийлүүлэгдсэн малын дунд шилмэл омгийн мал оролцуулж, тэднийг нутгийн малын дунд түгээн дэлгэрүүлэх суурийг тавьж өгсөн. Малжуулах сангийн төсөл нь зудын хохирлыг арилгах яаралтай арга хэмжээний нэг юм.



Гар худгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж

Гар худгийн кампанит ажил өрнүүлэх төслөөр, гар худаг гаргахад шаардагдах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг түрээсээр олгох, ажлын гарын авлага тараах зэргээр гар худаг гаргах ажлыг урагшлуулах бодит алхмуудыг хийсэн болно.



Сүү, сүүн бүтээгдэхүүн хамтран борлуулах төслийн бүлэг дээрх сургалт

Сүү, сүүн бүтээгдэхүүн хамтран борлуулах төслийн зорилго нь бүтээгдэхүүнийг жил тойрох борлуулах тогтолцоог бий болгох, малчдын бэлэн мөнгөний орлогыг нэмэгдүүлэх явдал юм.




Сүү, сүүн бүтээгдэхүүн хамтран борлуулах бүлгийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн

Ингэний буцалгаа, ааруул, шар тос зэрэг. Эрдэнэ сумын хувьд ингэний буцалгааг сумынхаа брэнд бүтээгдэхүүн болгохоор ажиллаж байгаа. (Дорноговь аймгийн төв дээрх тэмээн полони баяр, 2005 оны 1 сар)



Хонины ноос боловсруулах, бүтээгдэхүүн борлуулах бүлэг (жижиг эдлэл)-ийн дэлгүүр

Хонины ноос боловсруулах, бүтээгдэхүүн борлуулах төслөөр сумын иргэдийн бэлэн мөнгөний орлогыг нэмэгдүүлэх эрхэм зорилтын хүрээнд эсгий жижиг эдлэл үйлдвэрлэх 2 бүлэг, гэрийн эсгий үйлдвэрлэх 1 бүлэг гэсэн 2 төрлийн, нийт 3 бүлэг үйл ажиллагаа явуулж эхэлсэн болно.




Гэрийн эсгийн үйлдвэрийн дотоод байдал (Хонины ноос эсгийжүүлэх барабан ба эсгий дэлгэх тавцан)

Хонины ноос боловсруулах, бүтээгдэхүүн борлуулах бүлгүүдэд эхний хөрөнгө оруулалт хийгдэж, үйл ажиллагаа нь эхэлсэн. Гэрийн эсгийний хувьд эрэлт хэрэгцээ ихтэй, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үлдэгдэлгүй борлогддог.




Малчдын гэрт очиж сургалт зохион байгуулж буй байдал (Хөвсгөл сум, Талын цагааны худгийн малчдын бүлэг)

Бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын менежментийн төслөөр бүлэг өөрсдийн боловсруулсан төлөвлөгөөнд үндэслэн бүх үйл ажиллагааныхаа үр дүн, асуудалтай тал, шийдвэрлэх арга замыг бүлгээрээ хэлэлцэж, бүлэг өөрөө өөрсдийн үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн. Малчид бүгд бичиг үсгийн мэдлэгтэй байсан ба сургалтын үеэр саналаа картан дээр монгол хэлээр бичиж хадах байдлаар сургалтын үйл ажиллагаа явагдаж байлаа.




Богино яндант худаг (Эвдэрч орхигдсон ил байгууламж)

Газар доор 1м-ийн голчтой бетон цагираг залгаж хийсэн байдаг. Социализмын үед баригдсан бөгөөд малын хүчээр эргүүлж, ус татдаг байжээ. Гүний хувьд 2 – 30 м байдаг.



Богино яндант худаг

Богино яндант худгийн ил байгууламж өнөө үед өлдохоо больсон. Одоогоор ихэнх ийм худгийг ил байгууламжийг нь салгаж аваад, гараар ховооддог худаг болгон ашиглаж байна.



Бетон хашлагат худаг

Богино яндант худагтай адилхан малын хүчээр эргүүлэн ус өргөх насос суурилуулдаг байжээ. Доод хэсгийн бүтцээрээ богино яндант худгаас өөр, 168мм-ийн цагираг залгасан байдаг. 7 – 30м-ийн гүнтэй.



Гар худаг

Гүн 4 – 8 м орчим. Дотор талыг чулуу өрж бэхэлсэн байдаг. Ашиглалтын хугацаа 20-30 жил гэж яригддаг ба одоогоор олон худгийг сэргээн засварлах шаардлагатай болоод байна.



Талын цагааны худгийн бүлгийн өвөлжөө (Хөвсгөл сум, 2004 оны 12 сар)

Өвөлжөө нь гар худаг зэрэг уст цэгүүдтэй ойр, өвлийн хүйтэн жавар салхинаас нөмөрлөсөн өндөр бус толгойн өвөрт байрладаг. Гишүүн өрхүүдийн дунд салхин сэнс, нарны зай хураагууртай айл ч бий. Гэр доторх гэрэлтүүлэг, телевизор үзэх зэрэгт цахилгаан эрчим хүчийг ашигладаг. Зүүн талд буй парабол нь телевизийн антенн.

Хураангуй

1. Судалгааны ажлын тойм

(Судалгааны ажлыг хийх болсон нөхцөл байдал)

ХАА нь Монгол улсын хөдөлмөр эрхлэгч нийт хүн амын 40% (2004), ДНБ-ний 21%-ийг эзэлсэн эдийн засгийн гол салбар бөгөөд үүн дотроо МАА нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн 80%-ийг, экспортын бүтээгдэхүүний 5% (2004)-ийг эзэлж байна. Гэвч 1999, 2000 онуудад 2 жил дараалан үргэлжилсэн зудын улмаас 5.75 сая толгой мал хорогдож, ХАА-н үйлдвэрлэлийн хэмжээ 30%-иар буурахад хүрсэн байна.

Ийм нөхцөл байдлын дунд Монгол улсаас Япон улсын Засгийн газарт хандан говь хээрийн бүсийн 7 аймгийн нутагт худаг шинээр гаргах, сэргээн засварлах ажлын судалгааг хийж өгөх хүсэлт тавьсан билээ. Японы тал энэхүү хүсэлтийг авч үзээд, худаг шинээр гаргах, сэргээн засварлах төдийгөөр зудтай тэмцэх бүрэн дүүрэн арга хэмжээ болж чадахгүй тул бэлчээрийг төлөвлөгөөтэйгөөр ашиглах тогтолцоо болон худаг ашиглалт, хамгаалалтын тогтолцоог сайжруулах төлөвлөгөө болгон өргөжүүлэх санал дэвшүүлжээ.

(Судалгааны ажлын зорилго)

Монголын тал энэхүү саналыг хүлээн аваад, анх тавьсан хүсэлтээ эргэн харж, ① Зудын хохирлыг багасгах, бэлчээрийн талхдалыг арилгах зорилго бүхий бэлчээрийн төлөвлөгөөт ашиглалтын тогтолцоо болон худаг гаргах, сэргээн засварлах, ашиглалт хамгаалалтыг нь сайжруулах төлөвлөгөө боловсруулах, ② монголын талаас хамтран ажиллагсад ба Засгийн газрын холбогдох мэргэжилтнүүдэд технологи дамжуулах зорилго бүхий судалгааг хэрэгжүүлэх хүсэлт тавьсан юм.

(Судалгааны арга, түүний үйл явц)

Уг судалгаагаар, төслийн үр дүнтэй байдлыг тодорхой туршилтын судалгаагаар дамжуулан магадлах чиглэлийг баримталсан ба судалгааг доорх 3 үе шаттайгаар явууллаа.

- 1-р үе шат: 3 аймгийг хамарсан судалгаа явуулж, "Ерөнхий төлөвлөгөө" боловсруулсан.
Дундговь, Дорноговь, Өмнөговь 3 аймгийг хамарсан "Ерөнхий төлөвлөгөө" боловсруулах ажил явагдаж, үүнээсээ нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах аймгаар Дорноговь аймгийг сонгон авав.
- 2-р үе шат: Дорноговь аймгийн хэмжээнд судалгаа явуулж, "Нарийвчилсан төлөвлөгөө" боловсруулсан.
Дорноговь аймагт дахь судалгааны ажлын "Нарийвчилсан төлөвлөгөө"-г боловсруулж, уг ажлынхаа явцад туршилтын судалгаа хэрэгжүүлэх бүс нутгаар

аймгийн өмнөд хэсгийн Эрдэнэ, Улаанбадрах, Хөвсгөл сумдыг сонгосон ба туршилтын төслүүдийг сонгон тогтоож, тэдгээрийг хэрэгжүүлэх чиглэлийг төлөвлөв.

- 3-р үе шат: 3 сумдад туршилтын судалгаа явуулж, тэдгээрийн үр дүнг ерөнхий төлөвлөгөөнд эргэн тусгасан.

2 жил орчим хугацаанд туршилтын судалгаа явуулж, тэдгээрийн үр дүнг "Ерөнхий төлөвлөгөөнд эргэн тусгах" ажил хийгдлээ.

Энэхүү тайланд тэдгээр үр дүнг нэгтгэн харуулсан болно.

2 Судалгаанд хамрагдсан бүс нутгийн өнөөгийн байдал

2.1 Ерөнхий нөхцөл байдал

(Судалгаанд хамрагдсан бүс нутаг)

Судалгаанд хамрагдсан бүс нутаг болох 3 аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 349,600 км², хүн амын тоо 2004 оны байдлаар 150,000 орчим байна. Бүс нутгийн ерөнхий байдлыг доор тоймлон харуулав.

- Хүн амын нягтрал бага: Монгол улсад хүн амын нягтрал маш бага түвшинд байдаг. Үүнээс Өмнөговь аймагт хүн амын нягтрал улсын хэмжээгээр хамгийн бага буюу дунджаар 3.6 км²-д 1 өрх ноогдох байдалтай байна.
- Байгаль, цаг уурын хүнд нөхцөлтэй: Өвөл, зуны агаарын температурын ялгаа их, зундаа +25 хэмээс багагүй, өвөлдөө -20 хэмтэй байдгаас жилийн дундаж температур 0 хэм орчим байна. Эх газрын хуурай уур амьсгалтай тул жилд орох хур тунадасны хэмжээ харьцангуй бага, 120 – 160 мм орчим байдаг ба үүний 80% нь зуны улиралд унадаг.

2.2 Байгалийн нөхцөл

(Хотгор гүдгэр)

Монгол орны газар нутаг нийтдээ өндөрлөг бөгөөд далайн төвшнөөс дээш дунджаар 1,580 м-т өргөгдсөн байна. Нутгийн хойд хэсэгт 9 томоохон гол мөрөн урсдаг боловч судалгаанд хамрагдаж буй өмнөд хэсгийн говийн бүсэд гол мөрөн байхгүй юм. Гэхдээ Өмнөговь аймгийн нутаг дахь Алтайн нурууны салбар уулсад уулархаг газарт харьцангуй элбэг ордог борооны ус ба цасны хайлсан уснаас эхтэй булаг шанд олон буй.

(Гидрогеологийн ерөнхий байдал)

Уст үеийг (aquifer) ерөнхийд нь давхаргын (Granular Aquifer) ба ан цавын (Fissured Aquifer) гэж хувааж болох ба давхаргын уст үе нь 1) гол мөрний хэвлий дагуух, уул хоорондын хотгор газрын, дэвүүр хэлбэрийн газрын аллювийн (alluvial fan), 2) тал газрын өнгөн давхаргын өгөршсөн хурдсын, 3) цэрдийн галавын элсжин-хөрзөн чулууны гэсэн 3 төрөлтэй.

3 аймагт 2000 оны эцсийн байдлаар нийт 10,000 гаруй худаг байсан ба үүний 75 орчим хувийг эзлэх энгийн гар худгийн уст үе нь гол төлөв 1) ба 2) -р ангилалд багтах юм гэж үзэж болно. 3)-р ангиллын уст үе нь судалгаанд хамрагдаж буй аймгуудад хамгийн их тархсан байх бөгөөд Дорноговь аймгийн нутагт гүний ус оргилдог булаг шанд бүхий өргөн уудам бүс нутгийн дор энэхүү үе оршиж байх нь элбэг тохиолдоно.

(Судалгаанд хамрагдаж буй бүс нутгийн гидрогеологийн онцлог)

Бага гүнтэй инженерийн хийцтэй худгууд нь гол төлөв дөрөвдэгч галавын даралтгүй бага гүний уст үеийн, гүн худгууд нь цэрдийн галав зэрэг гүний даралттай уст үеийн ус бүхий худгууд байх магадлал өндөр байна.

(Уст цэгийн боломж)

Дорноговь аймагт цагийн хүрээний цахилгаан соронзон арга (ТЕМ)-ыг ашиглан усны хайгуул хийж, гидрогеологийн бүтцийнх нь талаар ойлголт авах материалуудыг бүрдүүлэв. Нийт 215 цэгт хэмжилт хийснээс 159 цэг (74%) дээр уст үе хүртэлх гүнийг нь хэмжиж чадсан бөгөөд гүний тархалтын хувьд 70м-140 м гүнтэй цэгүүд тэдгээрийн 75%-ийг, 60 м-ээс бага гүнтэй цэгүүд дөнгөж 16%-ийг эзэлж байгаагаас үзэхэд цаашид худгийн өрөмдлөгийн гүн нэмэгдэх хандлагатай байна.

(Газар доорх усны чанар)

Геоэкологийн хүрээлэнгээс эрхлэн судалдаг газар доорх усны мэдээллийн сан дахь 3 аймгийн эрдэсжилтийн үзүүлэлт уст цэгийн бараг тал хувьд нь ундны усны стандарт хэмжээ 1000мг/л-ээс илүү гарч байна. Мөн, туршилтын судалгааны хүрээнд шинээр гаргасан болон сэргээн засварласан худгуудыг оролцуулан Дорноговь аймгийн хэмжээнд нийт 127 цэгээс газар доорх усны дээж авч 29 үзүүлэлтээр усны чанарын шинжилгээ хийв.

Бага гүний ус агуулагч чулуулгийн (92 дээж авсан) усанд фтор (стандарт хэмжээнээс их, 78%), эрдэс бодис (мөн стандарт хэмжээнээс их, 30.3%) ихээхэн хэмжээгээр агуулагдаж буй муу үзүүлэлт гарсан ба 3 цэг дээр хүнцэл агуулагдаж буй нь илэрсэн байна. Гүний ус агуулагч чулуулгийн (35 дээж авсан) усны хатуулаг (стандарт хэмжээнээс их, 28.6%), эрдэс бодис (стандартаас их, 53.6%), хлорид (стандартаас их, 50.0%), магни (стандартаас их, 46.4%), фтор (стандартаас их, 64.3%) зэргийн үзүүлэлтээс харахад стандарт шаардлага хангахгүй дээж (цэг) олон байна.

Ийнхүү тус аймгийн газар доорх усны чанарын шинжилгээнээс хүний унданд ашиглахад тохиромжгүй нь харагдаж байгаа тул цаашид ямар нэгэн байдлаар цэвэршүүлэн ашиглах арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд одоогоор "эсрэгээр нэвтрэх шүүлтүүрийн арга"-ыг ашиглахаас өөр аргагүй гэж үзэж байна.

(Усны нөөцийн чадавхи, ашиглах боломжтой газар доорх усны нөөцийн хэмжээ)

Монгол орны усны макро солилцооны балансаас үзэхэд хур тунадасны 90% нь ууршиж, үлдсэн 10% нь гадаргын ус (6.3%), газар доорх ус (3.7%) болдог. Гадаргын усны 95% нь гадаад орнууд руу урсаж, хур тунадасны уснаас монголд гадаргуугийн ус болж 0.3%, газар доорх ус болж 3.7% нь л үлддэг байна.

Жилийн дундаж хур тунадасны хэмжээнд харгалзах газар доорх усны нөөцийг ашиглах боломжит хувь хэмжээ нь Дундговьд 2.3%, Өмнөговьд 1.0%, Дорноговьд 1.3% байна. Энэ нь говийн бүсийн бэлчээрийн даацыг дунджаар 3га/хонь/жил, хэрэгцээт ундны усны нэгж хэмжээг малд 5.0 л/өдөр, өрхөд 25-50 л/өдөр гэж тооцоход хангалттай хэмжээ юм. Гэхдээ газар доорх усны нөөцийн хэмжээ газар бүрт харилцан адилгүй, усны чанар ба ус өргөлтийн зардал ямар байх зэргийг харгалзан үзвэл усны чадавхи нь төдийлэн хангалттай бус байх тохиолдол бий.

2.3 Нийгэм эдийн засгийн нөхцөл

(Хүн ам ба ажил эрхлэлт)

Сумдын хүн амд хөдөөгийн хүн амын эзлэх хувь Дундговь аймагт 40.4%-85.2%, Дорноговь аймагт 29.1%-81.1%, Өмнөговь аймагт 65.1-85.7% байна. Дорноговь аймгийн сумдын хувьд хот суурин газрын хүн амын эзлэх хувь харьцангуй их байгаа нь Сибирийн хөндлөн тэнхлэгийн төмөр зам дайран өнгөрдгөөс дэд бүтэц, үйлчилгээний салбар харьцангуй түлхүү хөгжсөнтэй холбоотой юм.

Ажил эрхлэлтийн байдлыг үйлдвэрлэлийн салбар тус бүрээр авч үзвэл мал аж ахуй эрхлэгчид хамгийн олон байна. Дундговьд 80% орчим, Дорноговьд 45% орчим, Өмнөговьд 70% орчим хувийг мал аж ахуй эрхлэгчид эзэлж байна. Ганцхан Дорноговьд тээвэр, агуулах, харилцаа холбооны салбарт ажиллагсад 12.8%-ийг, уул уурхай, аж үйлдвэрийнхэн 2.8%-ийг эзэлж байгаа нь нөгөө 2 аймгаасаа өндөр үзүүлэлттэй байгаа юм. Харин Дорноговь, Өмнөговь аймгууд нь Хятад улстай хиллэх хил урт, энд арми, хилийн цэргийн анги салбар байнга байрлаж байдаг тул тэдгээрт ажиллах ажиллагсдын хувь хэмжээ арай өндөр байна.

(Эдийн засгийн ерөнхий байдал)

Дундговь, Өмнөговь аймгуудын хувьд эдийн засгийн секторт хөдөө аж ахуй-мал аж ахуйн секторын эзлэх хувь хэмжээ их, аймгуудын ДНБ-ий 45.3% болон 53.4%-ийг тус тус эзэлж байгаа бөгөөд энэ нь улсын дундаж болох 26%-иас бараг 2 дахин илүү байна. Харин Дорноговь аймгийн хувьд аж үйлдвэрийн сектор хамгийн их буюу ДНБ-ий 43.4%-ийг эзэлж байна.

3 аймагт 1 хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ Өмнөговь аймагт хамгийн их, 1999-2001 онуудад 413,000 – 484,000 төг байгаа нь мөн хугацаанд улсын дундаж 392,000 – 478,000 төг байснаас давж байна. Гэхдээ Дундговь аймаг зудын хохирлыг ихээр

хүлээсэн тул 1 хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ 1999 онд 511,000 төг байснаа 2000 онд 162,000 төг болж буурсан байна.

(Мал сүрэг)

3 аймгийн мал аж ахуйн салбар дахь тулгамдсан асуудлуудыг дурдвал:

- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж доогуур
- Байгалиас хараат, байгалийн гамшигт өртөмтгий, үүнтэй тэмцэх хүч сул
- Мал аж ахуйг тусгаар жижиг өрхүүд эрхлэн явуулдаг, нутаг дэвсгэр өргөн уудам, дэд бүтэц муу хөгжсөн
- Байнга нүүдэллэн явдаг нүүдэлчин ард түмний амьдралын хэвшил хэвээрээ бөгөөд орчин үеийн арга хэлбэрийг оруулах нөхцөл бололцоо хязгаарлагдмал

Зудын үед тэжээлийн дутагдал мал хорогдох нэг шалтгаан болдог. Гэтэл говийн бүсэд нутаг орноосоо малын тэжээл бэлтгэх нь байгаль экологийн нөхцлөөс шалгаалан хүндрэлтэй байдаг. Мөн монгол орны хойт хэсгийн өвс тэжээл бэлтгэдэг газраас алслагдан оршдог тул тээврийн зардал их гарч, үүнийгээ дагаад тэжээлийн үнэ ч харьцангуй өндөр болдог тул малчдад хангалттай хэмжээгээр худалдан авч бэлтгэхэд бэрхшээлтэй байдаг байна.

2.4 Хөдөөгийн нийгмийн байдал

(Орон нутгийн засаг захиргааны чадавхи)

Сумд хэрэглэх төсөвтэйгээ харьцангуйгаар орлого багатай, аймгийн татаасад түшиглэн үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ нь орон нутгийн хүн амд хүргэх нийгмийн үйлчилгээний бүтээмж, үр ашигтай байдалд ноцтой асуудал үүсгэж байгаа юм. Монгол улс бүхэлдээ зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжин орсноор төсөв мөнгөний хүрэлцээгүй байдлаас болж нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж нэлээд муудсан. Орон нутгийн иргэд энэхүү шинэ нөхцөл байдлын дунд өнөөг хүртэл байгаагүй бэрхшээлийг амсаж буй юм.

(Малчдын эдийн засгийн байдал)

5 ам бүлтэй ердийн малчин өрхийн орлого зарлагаар төлөөлүүлэн таамаг тооцоо хийж үзвэл 100 толгой малтай өрхийн борлуулалтын нийт орлого 666,200 төг, 200 толгой малтай өрхийнх 1,263,720 төг байна. Хүнсэнд хэрэглэх малын үнийг оролцуулбал дээрх тоо тус тус 950,400 төг ба 1,675,720 болж өснө.

Нийт зарлагын хувьд 100 толгой малтай өрхийнх 1,360,730 төг, 200 толгой малтай өрхийнх 1,617,950 төг байна. Зарлагад хамгийн их хэмжээ эзлэх нь хүнс, хувцас байгаа ба ядуу өрхийн хувьд ч ийм байдал илт харагдаж байна. 200 толгой малтай өрхийн орлого зарлага бараг адил хэмжээнд байгаа боловч 100 толгой малтай өрхийн хувьд зарлага нь орлогоосоо их байна.

(Малчдын хоршоолол)

Монгол 2 –10 малчин өрх 1 хот айлыг бүрдүүлж, нүүдлийн мал аж ахуйн өдөр тутмын үйл ажиллагаагаа хоршин зохицуулж, нэг ус, бэлчээрийг ашигладаг. Хот айлын бүрэлдэхүүн дэх өрхийн тоо нь бэлчээрийн даац багатай говийн бүс нутагт улсын дунджаас доогуур, 2 – 3 айлаас хэтэрдэггүй.

Монголын малчдын хоол хүнсний ихэнх нь малаас авах мах, сүүн бүтээгдэхүүнд тулгуурладаг. Тэрчлэн ахуйн хэрэгцээндээ малын арьс, үс, хонины ноосыг ашиглаж, аргалыг нь түлж, мал, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг борлуулах буюу сольж арилжаалан тэмээ, адуу, үхрийг уналга, тээвэрт өргөн ашиглана.

Цөөн малтай өрхүүд тээврийн хэрэгсэл байхгүйгээс нөхцлөөр илүү зах зээл бараадан, улирлын чанартай отор нүүдлээ хийх чадвар бага, байгалийн гамшигт өртөмтгий байдаг. Тэдэнд мөн хамтран ажиллах сэтгэл зүй төлөвшөөгүй, худалдаа арилжаа болон хэлцэл хийх чадвар дорой байна. Ялангуяа хөдөө орон нутгийн малчдын хувьд бараа солилцоо голлож, түүхий эд боловсруулалтын түвшин доогуур байгаа юм.

2.5 Судалгаанд хамрагдсан бүс нутгийн мал аж ахуй

(Судалгаанд хамрагдсан бүс нутгийн мал аж ахуйн онцлог)

Бэлчээрийн ургацын ангилал ба даац:

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгээс эрхлэн явуулсан бэлчээрийн чадавхийн судалгааны үр дүнгээс үзэхэд бэлчээрийн даац (хонин толгой/га) баруун бүс нутагт 47,0, төвийн бүс нутагт 69,7, зүүн бүс нутагт 89,4 байгаатай харьцангуйгаар говийн бүс нутагт 33,9 буюу хамгийн бага байна. Бэлчээрийн даацын эдгээр үзүүлэлт нь тогтмол тоо бус, цаг уурын нөхцөл байдлын нөлөөгөөр жил жилд нэлээд өөрчлөгддөг онцлогтой.

Бэлчээрийн чадавхи бага, тогтворгүй бүс нутгийн мал аж ахуй нь үндсэндээ нүүдлийн мал аж ахуй байдаг. Говийн бүсэд улирлын шинжтэй отор нүүдэл хийдэг тул мал идсэнээр бэлчээрийн нөөц баялаг багасах явдлаас чадварлагаар тойрон гарч ирсэн байна. Отор нүүдлийг голдуу сумынхаа нутаг дэвсгэрийн хүрээнд хийдэг боловч гантай жилд өөр сум, аймгийн нутаг дэвсгэр рүү орж, хол нүүх явдал байдаг.

Малын тоо ба малчин өрхийн тоо:

2002 оноос хойш малын тоо толгой өсөх хандлагатай болж, 2004 оны байдлаар Дундговь аймаг 1,781,000 (2002 оныхоос 21%-иар өссөн), Дорноговь 1,019,000 (мөн 23%-иар өссөн), Өмнөговь 1,070,000 (мөн 18%-иар өссөн) толгой малтай байсан байна. Малчин өрхийн тоо 1990-ээд оны үеэс огцом өсөж ирсэн ба 2001 оноос аажмаар буурч ирсэн байна. 2002 оны байдлаар Дундговьд 8040, Дорноговьд 3933, Өмнөговьд 6842 малчин өрх байсан байна.

Малын тоо толгойн нягтрал Дундговь аймгийн хойт хэсэгт илт их байна. Энэ нь Дундговийн хойт хэсэг тал хээрийн ургамлын бүсэд харьяалагддаг, урагшаах говийн бүс нутагтай харьцуулахад бэлчээрийн ургац сайтай, малчин өрхүүд мал хариулгын нөхцөл сайтай газарт төвлөрсөн байдгийн үр дүн юм гэж үзэж байна.

(Ургамалжилт ба бэлчээрийн даац)

Бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал :

Сүүлийн жилүүдэд Монгол улсын хэмжээнд бүс нутгийн чанартай бэлчээрийн хэт ачааллаас үүдэлтэй бэлчээр талхагдлын асуудал хурцаар тавигдаж байна.

Бэлчээр ашиглалтын ангилал :

Малчдын тархалт суурьшил тэнцвэргүй болон ашиглалтын байдлаас нь хамааруулан бэлчээрийг доорх байдлаар 5 ангилж байна.

Ашиглалтгүй:	Сумын төвөөс алслагдсан, эсвэл усны байгуулам (уст цэг) байхгүй бэлчээр
Бага ашиглагддаг:	Дээрхтэй адил. Гэхдээ тэмээ, адуу зэрэг бод мал бэлчээрлэх боломжтой. Мөн цас эсвэл нуур тогтсон үед ашиглах боломжтой.
Тохируулан ашигладаг:	Ургацынх нь хэмжээнд тааруулах тохиромжтой тоо толгойн хэмжээгээр улирлын чанартай отор хийж ашигладаг.
Их ашигладаг:	Өвөлжөөний ойр орчимд жилийн турш нутаглах үедээ, эсвэл ган гачгийн улмаас ургац муудсан зэргээс болж бэлчээрийн ашиглалтын ачаалал хэсэг хугацаанд ихсэх хэрэглээ.
Хэтрүүлэн ашигладаг:	Худгийн ойр орчмын болон хэтэрхий олон өвөлжөө ойролцоо байдаг зэрэг байнгын ачааллаас өвс ургамал нь талхлагдсан бэлчээр.

Өвөлжөө, хаваржааны бэлчээрийн жил тойрсон ашиглалт ба бэлчээрийн талхлагдал :

Өвөлжөө, хаваржаа нь ихэвчлэн усны төвшин харьцангуй өндөр, гар худаг гаргах боломжтой уулын бэл, толгодын хөндий, жалга, хотгор газрын захад байрладаг тул бэлчээрийн усан хангамж сайн байдаг. Харин зуслан, намаржаа нь тал газар байрладаг тул найдвартай уст цэг олоход бэрхшээлтэй, социализмын үед байгуулсан гүний худгууд ашиглах боломжгүй болсноор зуслан намаржааны бэлчээрийн зарим хэсэг ашиглалтгүй болон бага ашиглалттай газар болж хувирсан байна.

Үүнээс гадна малчид ус бэлчээр сэлгэн, улирлын чанартай отор нүүдэл хийхгүй болсон нь асуудал болоод байна. Зуслан, намаржааны усан хангамж муу байгаа явдал зохистой отор нүүдэл хийхэд саад болж буй нэг хүчин зүйл бөгөөд, өвөлжөө, хаваржаандаа жилийн турш нутаглаж, ойр орчных нь бэлчээрийг үргэлжүүлэн ашиглах сөрөг тойрогт ороод байгаа юм. Ийнхүү малчид өвөлжөө, хаваржааныхаа бэлчээрийг даацыг хэтрүүлэн ашиглах хандлага ажиглагдаж байна.

Гар худгийн усан хангамжийн чадавхиас хэтэрсэн малын бөөгнөрөл :

Говийн бүсэд гар худгийн ундарга 1-2 айлын 500 толгойгоос хэтрэхгүй тооны мал услахад хүрэлцэнэ. Гэтэл бодит байдал дээр 5-6 айлын 1500 гаран толгой мал цугларч, худгийн ойр орчны бэлчээрийн ургамалд хор хөнөөл учруулж байна. Үүнээс гадна ундарга маш багатай тул малаа тасралтгүй үргэлжлүүлэн услах явдал бэрхшээлтэй бөгөөд малчид бүхэл өдрийг малаа усалж өнгөрөөх үе ч байдаг. Ийнхүү бүтээмж багатай, их хугацаа зарцуулсан мал услах ажлын дүнд худгийн ойр хавьд олон мал багшрах нь бэлчээрийн талхагдлыг ихэсгэж байгаа юм.

Ургац ба даац :

Ургамлан нөмрөгийн ерөнхий төлөв :

Уг судалгааны ажилд мал аж ахуйн хүрээлэнгийн бэлчээрийн даацын мэдээллийг ашигласан ба ургамлан нөмрөгийн бүс нутгийн ялгаа, жил жилийн хэлбэлзэл, ойрын жилүүдийн ган гачиг зэргийг харгалзан үзэж, малын тоо толгойн стандарт (жилийн дундаж) хэмжээг аюулгүйн илтгэлцүүр 0.9-өөр үржүүлж гарсан тоог малын тоо толгойнд зохистой бэлчээрийн даацын хэмжээ гэж үзлээ.

Дундговь аймаг : Хойт талын сумдын хувьд ургамлан нөмрөгийн ангиллаар 60-97% нь Хээрийн хэв шинжид багтана. Өмнөд хэсгийн ургамалшилтын хувьд цөлөрхөг хээр(өндөр) хэв шинжид орох ба 57-96% орчмыг нь эзэлнэ.

Дорноговь аймаг : Зүүн өмнөд хэсгээр нь цөлийн ургамал өргөн тархсан. Ургамлан нөмрөгийн ангиллын хувьд аймгийн нийт нутгаар цөлөрхөг хээр(өндөр ба нам)-ийн хэв шинж илт давамгайл, 95-100%-ийг эзэлж байна.

Өмнөговь аймаг : Бэлчээрийн ургамлын тооцоот чадавхи 3 аймгийн дундаас хамгийн доогуур. Ургамлан нөмрөгийн ангиллаар Хээрийн хэв шинжид багтах сум байдаггүй, харин цөлөрхөг хээрийн ургамалшилт зонхилон тархжээ.

Бэлчээрийн даац :

Уст цэгийн эргэн тойрны 3 км-ийн радиустай тойргийг тогтвортой усжуулагдсан бэлчээр хэмээн үзэж ГМС ашиглан уг тойргийн талбай ба бэлчээрийн даацыг нь тооцоолон гаргалаа. Ингэхдээ уст цэг бүрийн чадавхийг харгалзан ойр орчных нь бэлчээрийн ашиглалтын түвшинг судлан тогтоож, production well гүний худаг 1.0, гараар татдаг уурхайн худаг 0.9, гар худаг 0.8, булаг шанд 0.7 гэж авлаа.

Дундговь аймаг : Хойт хэсгийн сумдад бэлчээрийн нэгж талбайн даац өндөр 50.1 хонин толгой/км² байхад өмнөд хэсэгт харьцангуй доогуур 33.0 х.т/ км² байна. Нийт аймгийн хэмжээгээр нь авч үзвэл 3 аймгийн дундаас усан хангамжийн түвшин илт өндөр (60.2%), аймгийн хэмжээний тогтвортой усжуулагдсан бэлчээрийн даац 1,800,000 хонин толгойд хүрэлцэхээр байна.

Дорноговь аймаг : Бэлчээрийн даац 29-35 х.т/ км² , дотроо онцгой их ялгарах газар үгүй. Аймгийн хэмжээний тогтвортой усжуулагдсан бэлчээрийн даац 1,293,000 хонин толгойд хүрэлцэнэ.

Өмнөговь аймаг : Бэлчээрийн даац аймгийн дунджаар 22.6 х.т/ км² байгаа нь 3 аймгийн дотор хамгийн бага үзүүлэлт юм. Усан хангамжийн үзүүлэлтээр мөн 3 аймаг дундаа хамгийн доогуур. Иймд нутаг дэвсгэрийн хэмжээ бусад аймгуудаас их ч гэлээ тогтвортой усжуулагдсан бэлчээрийн даац 1,286,000 хонин толгой байгаа нь ч 3 аймаг дотроо хамгийн бага нь байгаа юм.

Ашиглалтгүй ба бага ашиглалттай бэлчээрийн бодит байдал :

Ашиглалтгүй болон бага ашиглалттай бэлчээрийг бий болсон хүчин зүйл :

Малчдын суурьшилт тархалтын сийрэг байдал нь нэг хэсэг бэлчээрийг хэтрүүлэн ашиглаж, нөгөө хэсэг бэлчээрийг огт ашиглалтгүй болон бага ашиглалттай бэлчээр болгон хувиргах нөхцөл болж байгаа юм. Ашиглалтгүй болон бага ашиглалттай бэлчээр үүсэх 3 тодорхой хүчин зүйл байна. Уст цэгийн тархалт тохиромжгүй байгаа нь хамгийн ноцтой хэдий ч шийдвэрлэх боломжтой хүчин зүйл юм.

- Бэлчээр дэх уст цэгийн тархалт тохиромжтой бус.
- Сумын төв зэрэг төв суурин газраас алслагдсан байх (нийгэм эдийн засгийн хүчин зүйл)
- Бэлчээрийн чадавхи муу

Уламжлалт эх үүсвэрийг ашигласан бэлчээрийн усан хангамж :

Гар худаг, нуур цөөрөм, булаг шанд зэрэг уламжлагдан ашиглагдаж ирсэн уст цэгээс хангагдах усжуулагдсан талбай нь тогтвортой усжуулагдсан бэлчээрийн 60-80%-ийг эзэлнэ.

(Мал услах байгууламж)

Одоо буй худгуудын бүтэц зохион байгуулалт :

Судалгаанд хамрагдаж буй бүс нутгуудын худгуудыг өрөмдмөл худаг, богино яндант худаг, бетон хашлагат худаг, гараар ховооддог уламжлалт уурхайн (гар) худаг гэсэн 4 төрөлд хувааж болно. Худаг төрөл тус бүрийн бүтэц зохион байгуулалтыг доор үзүүлэв.

	Гүн (м)	Байх ёстой ундарга (л/с)	Бодит дундаж ундарга (л/с)
Өрөмдмөл худаг	40-200	1.0-аас дээш	2.87
Богино яндант худаг	18-40	0.3-0.6	0.79
Бетон хашлагат худаг	6-18	0.2-0.4	0.45
Гар худаг	2-9		0.24

Өрөмдмөл худаг :

Цооногт нь 168 мм голчтой хоолой залган хийсэн, суурилуулсан насосны хувьд усан дотор суурилуулах болон ус өргөх гэсэн 2 төрлийн насостой байна.

Богино яндант ба бетон хашлагат худаг :

Энэ 2 худаг дотоод зохион байгуулалтын хувьд өөр боловч 2-уланг нь малын хүчээр эргүүлэн ажиллуулдаг насос тавин ашиглаж байсан байна. Богино яндант худгийн дотор хэсэг нь өрөмдмөл худгийнхтай адил хоолой залган хийсэн байдаг бол бетон хашлагат худаг нь худгийн ёроолоос 1 м-ийн голчтой бетон цагиргуудыг давхарлан өрсөн зохион байгуулалттай байна.

Гар худаг :

Говийн бүсэд гар худгийг 7-8м гүнзгий ухаж, дотор ханыг нь чулуулгаар хашиж хийдэг. Гар худгийн засвар арчлалтыг хувь малчид өөрсдөө хариуцдаг хэдий ч хувь хүний өмч бус нийтийн эзэмшлийн өмч маягаар ашиглагдаж байна.

Услах байгууламжийн эвдрэл гэмтэл болон сэргээн засварлах арга :

Өрөмдмөл худаг :

Худаг хариуцах эзэнгүй хаягдсанаас хойш газар дээрх байгууламжийн мотор, худгийн барилга, усан сангийн ихэнх хэсэг эвдэрч, тоногдон дахин ашиглах боломжгүй болсон байна. Эвдрэл гэмтэл багатай худаг гэхэд л дараах байдалтай байна.

- Орос үйлдвэрийн насос эвдэрч, ус өргөх яндан нь тэр чигтээ цооногтоо үлдсэн.
- Усан доторх моторт насос эвдэрч, тэр чигээрээ цооног дотроо хаягдсан.
- Худгийн цооногийг таглаж, гагнан хамгаалсан байдалтай.

Эвдрэл гэмтэл бага худгийн хувьд эйрлифтийн аргаар худаг доторх булагдсан хэсгийг лайдаж цэвэрлэсний дараа усан доторх гүний шахуурга тавьснаар худгийг сэргээх боломжтой юм. Гэхдээ эвдрэл гэмтэл ихтэй худгийн хувьд цооног дотор орж бөглөсөн зүйлсийн байдлыг тодорхойлж чадахгүйн улмаас засварын ажилд ихээхэн цаг, зардал гарах ба бүрхэг зүйлс олон, амжилтад хүрэх магадлал тодорхойгүй тул шинээр худаг өрөмдсөн нь илүү хямд тусна.

Богино яндант худаг :

Малын хүчээр ажиллуулдаг насос нь эвдэрсэн тохиолдолд худгийн зохион байгуулалтын онцлогоос гараар ховоодон ашиглаж болдоггүй тул хаягдаж сүйтгэгдсэн худаг олон байгаа. Хаягдаж сүйтгэгдсэн худгуудын олонхи булагдсан байгаа тул гүнийх нь талаас бодоод үзсэн ч сэргээн засварласнаас шинээр гаргах нь зардлын хувьд хямд тусах юм. Харин цооногт нь гадны элдэв биет ороогүй байгаа худгуудын хувьд эйрлифтийн аргаар цооног дотор хуралдсан элсийг лайдах, цэвэрлэх замаар засварлах боломжтой.

Бетон хашлагат худаг :

Социализмын үед бетон хашлагат худаг гаргахад 1м-ийн диаметртэй нүх өрөмдөх чадвартай тусгай өрөмдлөгийн машин ашигладаг байсан ба одоо энэхүү өрөмдлөгийн машин байхгүй болсон тул бетон хашлагат худгийн хувьд зөвхөн сэргээн засварлах ажлыг хийж болох юм.

Уг нь бетон хашлагт худагт малын хүчээр ажиллуулдаг насос тавин ашиглаж байсан боловч уг насос нь одоо үйлдвэрлэгдэхээ больсон тул эдгээр худгийн олонхийг энгийн гар худагтай адил ховоогоор ус татах байдлаар ашиглаж байна. Мөн бага гүний худаг тул ундаргын хэмжээ багатайгаас гадна шүүлтүүр бөглөрсөн тохиолдолд сэргээн засварласан ч ундарга нь анх гаргасан үеийнхдээ хүрэхгүй байх нь их. Иймд, худгийг сэргээн засварлахын өмнө ундаргын хүчин чадлыг нь судалж, зөвхөн шаардлагатай ундаргын хэмжээнд хүрнэ гэсэн дүгнэлт хийгдсэн худгуудад насос суурилуулах нь зүйтэй.

Уламжлалт гар худаг :

Уламжлалт гар худгийг социализмын үед худаг усны мэргэжлийн хүмүүс гаргадаг байсан бөгөөд энэ ажлын арга технологи малчдад хадгалагдан үлдээгүй байна. Бүтэц зохион байгуулалтын хувьд худгийн дотор талыг чулуу өрж хамгаалсан байдаг тул зөвхөн нэг хэсгийг нь сэргээн засварлана гэдэг хүндрэлтэй, зарцуулагдах ажлын хувьд шинээр худаг гаргахтай адил шахам байна.

Элсэрхэг хөрстэй говийн бүсэд худаг ухахад хана нурах нь элбэг байдаг тул газар хөлдсөн байх хүйтний улиралд энэ ажлыг хийх нь зүйтэй байдаг. Гэхдээ малчид өөрсдийн хүчээр худаг гаргах болбол ажиллах хүчний шаардлагаас сургуулийн зуны амралтын үе болох зуны улирлыг сонгодог. Энэ үед газар доорх усны төвшин дээшилсэн байдаг тул ухах үеийн нуралтаас хамгаалахын тулд ус зайлуулах тоног төхөөрөмж хэрэгтэй болно. Зун хур борооны улиралд ухсан худагт ус гарсан ч гэсэн өвлийн улиралд усны төвшин доошилдгийг бодолцон дахин гүнзгийлж ухахгүй бол хүйтний улиралд ус ширгэж алга болох зэргээр худгаа жил тойрон ашиглахад хүндрэлтэй болох явдал бий.

Услах байгууламжийн ашиглалт, хамгаалалт :

Ашиглалт хамгаалалтын өнөөгийн байдал :

Инженерийн худгийг ашиглаж байгаа малчид өөр өөрсдийнхөөрөө тордон авч явж ирсэн байна. Иймд томоохон хэмжээний эвдрэл гэмтэл гарах тохиолдолд малчид ба засаг захиргааны аль аль нь засварын зардлыг шийдэж чадахгүй байдалд орж, худгийг тэр чигээр нь орхидог байжээ.

ХХААЯ болон бусад олон улсын донор байгууллагууд худгийн ашиглалт, хамгаалалтын асуудлыг шийдэхийн тулд хариуцагчийг нь тодорхой болгох шаардлагатай гэсэн нэгдсэн ойлголтод хүрээд байгаа бөгөөд инженерийн худгийг сэргээн засварлах буюу шинээр барихад ашиглалтын тогтвортой байдлыг хангах үүднээс сумын ЗДТГ, малчдын бүлгийн хооронд бичгийн хэлбэрээр гэрээ байгуулдаг болж байна.

Гар худаг :

Гар худгийг малчид хамгийн их ашигладаг бөгөөд үндсэндээ уламжлан

эзэмшиж ирсэн малчин нь юмуу бүлэг малчин өрх ашиглаж, хамгаална. Ашиглалт хамгаалалтын талаар тогтсон журам байхгүй, тухайн худгийн байдлаас шалтгаалан ашиглагчид нь тус тусдаа зохих арга хэмжээг авч явдаг.

Худгийн ажилд малчдын хариуцах зардал ба худгийн ашиглалт :


2005 оны 6 сард ХХААЯ, БОЯ, Сангийн яамны сайд нарын хамтарсан тушаалаар батлагдсан "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-ын дагуу шинээр гаргах, сэргээн засварлах худгийн ажлын зардлын тодорхой хэсгийг малчид хариуцахаар боллоо. Энэхүү зардлыг малчид худгийн барилгын ажил эхлэхээс өмнө урьдчилан төлөх ёстой юм.

Малчдын хариуцах зардлын хэмжээ сэргээн засварлах худгийн хувьд барилгын ажлын зардлын 10%-иас дээш, шинээр гаргах худгийн хувьд 5%-иас дээш байна. Малчид холбогдох зардлаа төлсний дараа сумын ЗДТГ, барилгын ажлын гүйцэтгэгч, малчдын хооронд гурвалсан гэрээ байгуулагдсанаар тухайн худгийг эзэмших эрх малчдад шилжинэ.

Ус хангамжтай холбоотой зардлууд :

Засвар үйлчилгээний зардал :

Засвар үйлчилгээний зардал нь суурилуулсан тоног төхөөрөмжид шаардлагатай тогтмол зардал ба худгийг ажиллуулах бүрт шаардагдах хувьсах зардлаас бүрдэнэ. Тусгай моторчин ажиллуулах эсэх, малын тоо толгой 1000 байх уу, 2000 эсвэл 3000 байх уу зэрэг нөхцлүүдийг харгалзан үзэж, засвар үйлчилгээний зардлыг тооцооллоо.



SP5A-8 маркийн насос (ус өргөх гүн 40м орчим, мотор KDE200C)-той үеийн малын тоо ба 1 хонины 1 удаагийн усалгааны хамаарлыг зургаар үзүүлэв.

Байнгын моторчин ажиллуулах тохиолдолд моторчингүй байснаас 1.5 дахин их зардал гарч байна. Ашиглалтын зардлыг хэмнэхийн тулд мотор ажиллуулах малчны малыг бүлгийн бусад гишүүн хариулах, эсвэл гишүүд ээлжээр мотороо ажиллуулах зэргээр зохицуулах шаардлагатай ба аль ч тохиолдолд малчдын бүлгийн гишүүдийн хамтын ажиллагаа чухал байх юм.

Мөн, малын тоо толгой ойролцоогоор 2000-аас цөөн байх тохиолдолд ашиглалтын зардал эрс нэмэгдэнэ. Насос суулгах үедээ олон малчид үр бүтээмжтэйгээр ашиглах тогтолцоог нь бүрдүүлж өгөхгүй бол цөөн тооны хэрэглэгчдэд их ачаалал хуваарилагдаж, насосны тогтвортой ашиглалтад саад учруулна.

Услах байгууламжийн хүндрэлтэй асуудлууд:

Уст цэгийн улирлын чанартай ашиглалт :

Говийн малчид жилдээ хэд хэдэн удаа нүүдэл хийдэг тул 1 жилийн дотор 1 худгийг ашиглах хугацаа богино, ашиглахгүй хугацаа нь урт байдаг. Худаг хариуцагч усан доторх насосоо худаг дотор байрлуулсан чигээр нь зөвхөн мотороо салгаж аваад явдаг. Насосыг удаан хугацаагаар худаг дотор нь орхивол хоолой нь зэвэрч, дахин ашиглахад насосын дотор хэсгийн элэгдэл түргэсдэг.

Өвлийн улирлын ашиглалт :

Өвлийн улиралд хасах 40 хэм хүртэл хүйтрэх үе байдаг ба энэ үед усан сан болон ус дамжуулах хоолой хөлддөг тул усыг усан сангаар дамжуулалгүй шууд онгоцонд хийх болдог. Онгоцны хэмжээ бага тул насосыг олон дахин ажиллуулснаар элэгдлийг нь түргэсгэдэг байна.

Аймгууд дахь худгийн засвар үйлчилгээ, хяналтын байдал :

Хуулиар орон нутаг дахь худгийн засвар үйлчилгээ, хяналтын ажил нь аймгийн ЗДТГ-ын ажил үүргийн хүрээнд хамаардаг боловч бодит байдал дээр худаг усны мэргэжлийн компанид энэ ажлыг даалган хийлгүүлж байна. Энэхүү засвар үйлчилгээний ажилд худаг бүртгэлийн дэвтрийг ашигладаг ба бүртгэлийн дэвтэрт тэмдэглэх мэдээллийг цуглуулахад ихээхэн хөдөлмөр шаардагддаг. Худгуудын нэр ба бүртгэлийн дугаар таарч байсан ч бодит байдал дээр худгийн байршил зөрөх тохиолдол гардаг.

(Зах зээлийн эргэлт ба мал аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын асуудал)

Говийн бүсэд малчдын ихэнх нь сумын төвөөс 30-аас дээш км алсад нутагладаг. Мөн бэлэн мөнгөний орлого байхгүйгээс малчид ба ченжүүдийн хооронд голчлон бараа түүхий эд солилцох хэлбэрийн наймаа явагддаг. Өргөн уудам нутагт тархан амьдрах багахан аж ахуйтай малчдын худалдан авах чадвар доогуур, малчид наймаанд ашиггүй байр сууринд байдаг.

(Малын хашаа хороо)

Малын хашаа хороо нь өвлийн хүйтэн, салхи шуурганаас малыг хамгаалах, ялангуяа хавар мал төллөх цагаар хээлтэй эх мал, нялх төлийг хамгаалах зориулалт бүхий мал аж ахуйн чухал байгууламж юм. Одоо ашиглагдаж байгаа малын хашаа хорооны ихэнх нь социализмын үед байгуулагдсан бөгөөд нэгдэл тарсны дараа малчдад шилжиж, зарчмын хувьд хувийн өмч болсон байна. Малын хашаа хороог мод, чулуу, хөрзөнгөөр барьсан байдаг. Дорноговь аймагт хийсэн судалгааны үр дүнгээс харахад 1 өрхөд ноогдох хашааны тоо нь 0.64 буюу 2-3 өрхөд 1 хашаа ноогдох байдалтай байна.


3 Мал аж ахуйн тогтолцоог сайжруулах төлөвлөгөөнд тусгагдсан хөгжлийн чиг хандлага

Зудын хохирлын шалтгаан, үр дагаврын холбоо ба хөдөөгийн мал аж ахуйн хөгжилд саад болж буй хүчин зүйлүүдийг тодорхойлж, эдгээртээ үндэслэн цаашдын хөгжлийн чиг хандлагыг судалж, төлөвлөгөөний ерөнхий цар хүрээг гаргаж ирлээ.

3.1 Зудын хохирол үүсэх нөхцөл байдал

Зудын хохирол нь өнгөрсөн хугацаанд ч гэсэн ган гачиг болох, их цас орох зэрэг цаг уурын нөхцлүүдээс шалтгаалан тодорхой хугацаанд давтагдаж ирсэн байна. Гэхдээ 1990-ээд оноос хойш зудын хохирол эрс нэмэгдсэн нь төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих үеэр нэгдэл тарж, малыг хувьчилснаар нийгмийн янз бүрийн өөрчлөлт явагдаж, зудын хохирлыг үүсгэх хүчин зүйлүүд шинээр бий болсонтой холбоотой.

Өөрөөр хэлбэл, социализмын үед мөрдөгдөж байсан бэлчээр ашиглалтын хязгаарлалт, худгийн ашиглалт хамгаалалтын тогтолцоо үгүй болж, тэжээл бэлтгэлийн тогтолцооны чадавхи доройтон, амиа аргацаасан жижиг өрхийн аж ахуй илт олширч, бэлэн мөнгө л байхгүй бол яаж ч чадахааргүй нөхцөл байдал үүссэнээс бэлэн мөнгөөр арилжихад хялбар ноолуурыг нь авахын тулд малчид ямааныхаа тоо толгойг өсгөсөн зэргээс шалтгаалан зудын хохирлын эрсдэл өндөрсөн байна. Хамгийн том асуудал нь дээрхийн уршгаар 1 толгой малд ноогдох ашиглах боломжтой бэлчээрийн талбай багассан явдал бөгөөд, мал сүрэг онд ороход шаардлагатай тарга тэвээргээ авч чадалгүй хүйтэн өвөлтэй золгож, төлөвлөгөөт эдийн засгийн үеийнхтэй харьцуулахад зудын хохиролд хялбар өртөхөөр тогтолцоо бий болсон байна.



(Зудын эсрэг арга хэмжээ)

Зуд үүсэх шалтгаан нь ярвигтай олон талтай тул түүнээс үүдэн гарах хохирлыг багасгах арга хэмжээг ч гэсэн олон янз, биет болон оюунлаг олон талын элементүүдээс бүрдэх нийлмэл цогц арга байдлаар авч хэрэгжүүлэх шаардлагатай. "Зудын эсрэг арга хэмжээ"-г дараахь байдлаар тодорхойлж болно.

- Зудын эсрэг арга хэмжээнд шаардлагатай байгууламжуудыг барьж байгуулах, сайжруулах: Усан хангамжийг сайжруулах (худаг байгуулалт), хашаа саравч барих г.м.
- Үйлчилгээний тогтолцоог сайжруулах: Мал эмнэлгийн үйлчилгээ, малын үүлдэр угсаа сайжруулах, тэжээл бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулах.
- Ажлын байрны тоог өсгөх: Цөөн малтай малчдыг хамруулах зорилготой бүс нутгийн хөгжлийн бодлого.
- Бэлэн мөнгөний орлого олох боломжийг бүрдүүлэх: Аж ахуй эрхлэгчдийг сургаж, төлөвшүүлэх.

3.2 Хөдөөгийн мал аж ахуйн хөгжилд саад болж буй хүчин зүйлүүдийн дүн шинжилгээ

(Уст цэг, бэлчээрийн нөөцтэй холбоотой хүчин зүйл)

Малчид, говийн бүс нутагт унах өчүүхэн хэмжээний хур тунадсыг зунд тогтоол уснаас малаа услах, өвөлд цастай газар нүүдэллэх байдлаар тохируулан ашигладаг боловч мал усалгаанд худгийг буюу газрын доорх усыг ашиглах явдал зайлшгүй чухал юм. Гэвч худгийн тоо цөөн байгаа тул хязгаарлагдмал тооны уст цэгүүдийн орчимд мал бөөгнөрч, бэлчээр доройтох гэсэн даац хэтрэлтийн асуудлыг үүсгэж байна.

(Мал аж ахуйн үйлдвэрлэлтэй холбоотой хүчин зүйл)

Мал сүргээ өрхийн хэрэгцээнд хэрэглэж буй тооноосоо илүү гарган өсгөж явах тогтвортой хэмжээнд хүргэж чадаагүй малчин өрх олон байгаа бөгөөд өрхийн аж ахуйн хэмжээ ийм жижиг байгаа нь мал аж ахуйн хөгжилд саад болж буй эн тэргүүний хүчин зүйл мөн. Тэрчлэн голдуу залуу малчдын хувьд мал маллагааны арга туршлага, мэдлэг дутмаг байгаа тухай асуудал ч яригдаж байгаагаас гадна мал эмнэлгийн үйлчилгээ, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо зэрэг малын эрүүл мэнд, эрүүл ахуйтай холбоотой талууд, мал даатгалын тогтолцоо ба өвс тэжээл зэрэг гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн бүтэц, зохион байгуулалт бий болоогүй байгаа нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангахад саад учруулж буй хүчин зүйл болж байна.

(Бэлэн мөнгөний орлоготой холбоотой хүчин зүйл)

Малчдын бэлэн мөнгө олох боломж хаврын ноолуур борлуулалт ба өвлийн мал мах борлуулалт гэсэн 2-хон улирлаар хязгаарлагдаж байдаг ба энэ байдлыг халахын тулд аж ахуйн үйл ажиллагааг олон талтай болгож, орлогын 3-дагч тогтвортой эх үүсвэрийг бий болгох шаардлага гарч ирж байгаа юм. Гэвч малчид шинээр үйлдвэрлэл эхлүүлэн эрхлэх мэдлэг дутмаг, үүнд шаардагдах хөрөнгө мөнгө ч тэдэнд байхгүй байна. Мөн зах зээл болон ойр орчны нийгмийн дэд бүтэц муу зэргээс зах зээлтэй сайтар холбогдож чадахгүй байгаа зэрэг нь бэлэн

мөнгөний орлогын шинэ эх үүсвэрийг бий болгоход саад учруулж буй хүчин зүйл болж байна.

(Хүний нөөц-хүний нөөцийг бэлтгэхтэй холбоотой хүчин зүйл)

Мал аж ахуйн системд учирч буй бэрхшээлүүдийн нэг нь тулгамдсан асуудлыг үр дүнтэй, бүтээлчээр шийдвэрлэх чадавхи орон нутгийн засаг захиргаа, малчдын аль алинд нь дутагдаж буй явдал юм. Энэ бэрхшээл 2 талтай бөгөөд 1-рх нь орон нутгийн захиргаа болон малчдын аль алинд нь чадвар дутагдаж байгаа, 2-рх нь тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд 2 тал хангалттай хэмжээнд хамтран ажиллаж чадахгүй байгаа явдал юм.

3.3 Хөгжлийн нөөц бололцоо

(Усны нөөц)

2003 онд хийгдсэн худгийн тооллого судалгааны дүнгээс үзэхэд "ашиглагдахгүй байгаа худаг" олон, үүнд худаг бүтцийн хувьд нарийн болохын хэрээр ашиглагдахгүй байгаа хувь хэмжээ нь өндөр байна. Ашиглагдахгүй байгаа инженерийн худгуудын хувьд сэргээн засварлах боломжтой бол шинээр гаргаснаас хямд зардлаар ашиглалтад оруулж болох тул ийм худгууд нь усны нөөц ба бэлчээр ашиглалтыг сайжруулахад томоохон нөөц бололцоо болох юм.

(Бэлчээрийн нөөц)

Ашиглалтгүй болон бага ашиглалттай бэлчээр бий болоход: 1) найдвартай уст цэг байхгүй, эсвэл хүрэлцээгүй, 2) хүн ам олноор суурьшсан газраас алслагдсан, 3) бэлчээрийн ургац муу байх гэсэн 3 хүчин зүйл хоорондоо ямар нэг байдлаар уялдан нөлөөлж байна. Алслагдсан нутгийн асуудлын хувьд нийгэм, эдийн засгийн онцлог хүчтэй илэрдэг бол бэлчээрийн ургац хангалтгүй байдлын хувьд байгалийн хүчин зүйлийн нөлөө давамгайлдаг. Харин нөгөө талаар найдвартай уст цэгийн асуудалд байгалийн болон нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүд аль аль нь хамааралтай хэдий ч нөгөө 2 хүчин зүйлийг нь шийдвэрлэж чадвал энэ асуудлыг шууд шийдвэрлэх арга зам аяндаа харагдах тул хөгжлийн нөөц боломжоор харьцангуй хамгийн өндөр юм.

(Орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхтэй холбоотой нөөц бололцоо)

Орон нутагт, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл хязгаарлагдмал, техник технологи, мэдээлэл, цахилгаан эрчим хүчний хангамж, зах зээлийн цар хүрээ зэрэг шийдвэрлүүштэй асуудлууд байсаар байгаа тул өнөөгийн байдлаар нөөц бололцоо сайтай гэж хэлэхэд хэцүү. Гэхдээ мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах жижиг үйлдвэрүүд тогтвортой үйл ажиллагаа явуулж чадвал малчид түүхий эдээ борлуулах газартай болж, орон нутгийн малчид, иргэдэд орлогын шинэ эх үүсвэр нээгдэх бөгөөд үүн дундаас эсгийн үйлдвэрлэл, сүүн бүтээгдэхүүн борлуулалтын асуудлыг малчид их сонирхож байгаа юм.

3.4 Хөгжлийн чиг хандлага

(Бэлчээрийн менежменттэй цогц байдлаар авч үзэх худаг байгуулалтын төлөвлөгөө боловсруулах нь)

Өнөөгийн бэлчээр ашиглалтад газар нутгийн тэнцвэргүй байдал ажиглагдаж, хязгаарлагдмал тооны уст цэгийн орчмыг жил тойрон хэт ашиглах явдал ихсэж буй нь зарим хэсэгт бэлчээрийн доройтол үүсэх нөхцлийг бий болгож байна. Иймд мал аж ахуйн тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд бэлчээр ашиглалтын үзүүлэлтийг дээшлүүлэх, өөрөөр хэлбэл бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх зорилго бүхий бэлчээр усжуулалтыг сайжруулах, ашиглалтгүй болон бага ашиглалттай бэлчээрт тогтвортой уст цэг бий болгоход чиглэсэн худаг байгуулалтын ажлыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

(Цогц байдлаар хандах нь)

Уг судалгаагаар төслийн үе шатны менежментийн аргыг ашигласан сургалт явуулж, тэрхүү сургалтын явцад малчид өөрсдөө өөрсдийнхөө өнөөгийн байдлыг үнэлэн дүгнэж, уг байдлаа сайжруулахын тулд төслийн санал дэвшүүлсэн. Энд худаг байгуулалтаас гадна жижиг үйлдвэрлэлийн төслүүдийн санал ч олноор дэвшүүлэгдэн гарч ирсэн болно.

(Мал аж ахуйг сайжруулах төлөвлөгөөнд ядуурлыг бууруулах, малын тоо толгойг зохистой хэмжээнд байлгах асуудлыг чухалчлан авч үзэх нь)

Хөдөөгийн малчдын ихэнх нь 150-иас доош толгой малтай ядуу давхаргын жижиг аж ахуйтнууд байгаа ба ядуурлыг бууруулахад тэдгээрийн малын тоо толгойг нэмэгдүүлэх явдал чухал нөхцөл болон тавигдах юм. Гэхдээ малын тоо толгой огцом өсөх нь зудын хохирол үүсэх нэгэн хүчин зүйл болох тул мал маллагааны арга технологийг боловсронгуй болгох, худаг ус гаргах зэрэг мал аж ахуйг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг дээрхтэй цогц байдлаар хэрэгжүүлж явах шаардлагатай.

(Малчдыг зохион байгуулалтад оруулах шаардлага, эзэн хүний сэтгэлгээг төлөвшүүлэх)

Хөдөөгийн мал аж ахуйн үйлдвэрлэлийг өргөтгөж, ядуурлыг бууруулахын тулд малчдыг зохион байгуулалтад оруулан, дан дангаараа шийдвэрлэж чадахгүй бэрхшээлийг малчид, иргэд хамтран хүчээ нийлүүлэн шийдвэрлэж явах ёстой билээ.

Шинээр хэрэгжүүлэх төслийг малчдын зохион байгуулалтад орох ажлыг дэмжих хөшүүрэг болгон ашиглах нь үр дүнтэй ажил болох юм. Төсөлд хамрагдагсдад эдийн засгийн хариуцлага үүрүүлж, хэрэгжүүлэх төслийн эзэд нь өөрсдөө юм гэдгийг нь ухамсарлуулж, зохион байгуулалттай үйл ажиллагааных нь тогтвортой үргэлжлэх магадлалыг өндөрсгөж өгөх нь чухал.

(Малын үүлдэр угсааг сайжруулах)

Бэлчээрийн байдал сайн үед хүч чармайлт гаргавал мал түргэн өсдөг. Одоогийн байдлаар зудаар малаа ихээхэн хорогдуулсан малчид малаа дахин өсгөхийг зорьж байгаа боловч тоо толгойг нь өсгөхөөсөө илүү малынхаа үүлдэр угсааг сайжруулахад чухалчлан анхаарч, 1 малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх замаар орлогын нийт хэмжээг тогтвортой байлгах чиг хандлагыг барих нь зүйтэй юм.


(Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг залгамжлах болон байгаль орчны хамгаалах)

Өвс ургамал багатай говийн бүс нутагт суурин амьдралыг бий болгох нь байгаль орчин эвдэгдэх, бэлчээрийн мал аж ахуйн тогтолцоог алдагдуулж болзошгүй аюултай. Бэлчээрийг тогтвортой ашиглахын тулд улирлын чанартай отор нүүдэл хийн малаа адгуулдаг уламжлалт аргыг дэмжиж ажиллах нь чухал.


3.5 Хөгжлийн бүрэлдэхүүн хэсгүүд ба төсөл (Хөгжүүлэх бүтэц)

Өнөөг хүртэл өгүүлсэн асуудал бэрхшээл, саад болж буй хүчин зүйлүүд, нөөц боломжуудын дүн шинжилгээг харгалзан, хөдөөгийн мал аж ахуйн тогтолцоог сайжруулахын тулд өмнө дурьдсан үндсэн чиглэлийн дагуу доорх зургаар харуулах 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэх бүтцийг бий болгох шаардлагатай хэмээн үзэж байна. Бүрэлдэхүүн хэсэг тус бүр нь төслүүдээс бүрдэнэ.

Тодруулсан асуудал, бэрхшээл




Хөгжлийн бүрэлдэхүүн хэсгүүд



3.6 Хөгжлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн тэргүүлэх дарааллын тухайд

“Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежментийн бүрэлдэхүүн хэсэг”-ийг хөгжлийн 4 бүрэлдэхүүн хэсгүүдийн дотроос нэн тэргүүнд авч үзвэл зохино. Бэлчээрийн үр дүнтэй ашиглалт, худаг байгуулалт, менежментийн асуудал нь бүс нутгийн бэлчээрийн мал аж ахуйн суурь дэвсгэр төдийгүй мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой явуулах хамгийн чухал урьдчилсан нөхцөл мөн.

“Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулах” бүрэлдэхүүн хэсэг нь мал аж ахуйн салбарын тогтвортой өсөлтийг хангах, түүний тасралтгүй хөгжлийг бодит зүйл болгоход чухал шаардлагатай. “Малчин өрхийн орлогыг тогтворжуулах” бүрэлдэхүүн хэсгийн хувьд ихээхэн үр нөлөөлөл үзүүлэх найдлага төрүүлж байгаа хэдий ч мал аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эд нийлүүлэлт тогтвортой байх эсэхээс шууд хамаарах тул харьцангуй туслах чанарын бүрэлдэхүүн хэсэг юм.



4. Туршилтын төслийн судалгаа

(Туршилтын төслийн судалгааны зорилго)

Туршилтын төслүүдийг, тэдгээрийн хэрэгжих боломж, үр ашигтай байдал зэргийг тодруулахын хамтаар туршилтын төслийн судалгаагаар хуримтлуулсан туршлагыг судалгааны явцад боловсруулах үндсэн төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжих магадлал өндөртэй, амьдралд ойр дөт төлөвлөгөө боловсруулан гаргахын тулд хэрэгжүүллээ.

(Нарийвчилсан төлөвлөгөөнд хамрагдсан бүс нутгийн сонголт)

Хэрэгжиж буй бусад төслүүдтэй давхардуулахгүй байх явдал ба судалгаанд шаардлагатай ажлын нөхцөл байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр ерөнхий төлөвлөгөөнд хамрагдсан 3 аймгийн дотроос нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах аймгаар Дорноговь аймгийг сонгож авлаа.

(Туршилтын төсөл хэрэгжүүлэх сумдын сонголт)

Уг төсөл нь нэг талаар зудын эсрэг яаралтай арга хэмжээнд хувь нэмэр оруулах зорилтыг агуулж байгаа бөгөөд багахан цар хүрээтэй ч гэсэн тодорхой хэмжээний барилгын ажлуудыг хийх тул “зудаар хүлээсэн хохирлын хэмжээ” нь сонголтын

нэгэн чухад шалгуур болсон. Дорноговь аймгийн урд хэсгийн Эрдэнэ, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумд зудад өртөмтгий, амссан хохирлын хэмжээ их байсан тул төсөл хэрэгжүүлэх дарааллаар тэргүүний ээлжинд тавигдаж байсан. Гэхдээ Хатанбулагийн хувьд хэт алслагдсан сум тул судалгааны ажлын цаг хугацаа хязгаарлагдмал нөхцөл байдлын улмаас хасч, бусад 3 сумыг нь туршилтын төсөл хэрэгжүүлэхээр сонгон авсан болно.

4.1 Туршилтын төслийг хэрэгжүүлэх арга зам

(Гишүүдийн бүрэн оролцоог хангах хэлбэрийн төлөвлөлт)

Туршилтын төслийн хэрэгжилтийн явцад төслийг хэрэгжүүлэгч бөгөөд түүний үр шимийг хүртэгчид болох малчдын санаа бодлыг тэргүүний ээлжинд харгалзан үзнэ. Малчид өөрсдөө бүлэг зохион байгуулж, үүндээ тулгуурлан төслийн санал бичгээр боловсруулах гэсэн гишүүдийн бүрэн оролцоог хангахуйц санал боловсруулах аргыг ашиглах байдлаар туршилтын төсөлд хандах эзэн хүний сэтгэлгээг өндөржүүлэн илүү бүтээлч, тогтвортой төсөл хэрэгжүүлэн, удирдаж явах тогтолцоог бий болгох зорилт тавьсан.

(Туршилтын төслийг хэрэгжүүлэх дараалал)

Хэрэгжүүлэх дараалал :

Туршилтын төсөл нь малчид ба иргэдийн өөрсдөө боловсруулсан төслөөс сумын ЗДТГ ба судалгааны баг сонгон шалгаруулах гэсэн процессоор эхэлнэ. Юуны өмнө бүлэг төслийн саналаа боловсруулах тул өөрсдийн бодит байдлын талаар ойлголт авахын тулд Төслийн үе шатны менежментийн сургалт (PCM Workshop) –ыг зохион байгуулна. Дараа нь сургалтаар гарч ирсэн асуудалд хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан бүх бүлгүүд төслийн саналаа боловсруулж, судалгааны баг ба сумын ЗДТГ-аар шалгуулан, эндээс туршилтаар хэрэгжүүлэх төслүүд шалгарч, хэрэгжилтэндээ орно.

Сургалт явуулсан тухай болон сургалтаар дамжин хэрэгжсэн зохион байгуулалтын тухайд :

Сургалтыг, анх явуулсан “Төслийн үе шатны менежментийн сургалт” ба шалгарсан төслийн бүлгээс зохион байгуулах “Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сургалт” (PO Workshop) гэсэн 2 үе шаттайгаар зохион байгууллаа.

Мөн тогтмол хугацаанд мониторинг явуулж, төслийн ажлын явц ямар байгааг тодруулан, төслийн хэрэгжилтэд саад учруулж буй асуудлыг цаг алдалгүй илрүүлж, үүндээ үндэслэн “чиг шугамаа” залруулан тодотгож явсан. Тэрчлэн мониторингийн дүгнэлт дээр үндэслэн туршилтын судалгааны явцад гарч буй өөрчлөлтийн талаар бүрэн дүүрэн ойлголт авах, өөрөөр хэлбэл төсөл хүлээсэн үр дүнд хүрч байна уу, үгүй юу гэдгийг мэдэж, “Зөвлөмж” , “Зааварчилга” боловсрууллаа.

Төслийн саналын сонгон шалгаруулалт :

Малчид, иргэдээс ирсэн төслийн саналуудаас судалгааны багийн боловсруулсан төслийн шалгуурын дагуу сонгон шалгарууллаа. Үүнээс гадна судалгааны багаас газар дээр нь очиж байдлыг ажиглах ажиглалт ба малчдын бүлгийн үйл ажиллагааны туршлагын талаарх хялбар асуулга судалгааг давхар явуулсан. Мөн, зөвхөн малчдын санал хүсэлтээр хязгаарлалгүй мал аж ахуйн ирээдүйн хөгжил гэсэн байр сууринаас хандаж, сумын захиргаа ба судалгааны баг хоорондоо зөвлөлдсөний үндсэн дээр туршилтын төслүүдийг сонгон шалгаруулсан болно.

4.2 Шалгарсан төслүүд ба хөдөөгийн МАА-н тогтолцоог сайжруулах төлөвлөгөөний хамрах хүрээний хоорондын хамаарал

(Туршилтын төслүүдийг эцсийн байдлаар товлосон нь)

Гарч ирсэн төслийн саналуудыг хянаж үзсэний дүнд дараар төслүүдийг шалгаруулсан.

Туршилтын төслүүдийн нэр	Хэрэгжүүлэх сумд	Хэрэгжүүлэгчид	Дэвшүүлсэн зорилт
Бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын төсөл	3 сум*	Малчдын бүлгүүд	Бэлчээрийн талхагдлыг багасгах
Малжуулах сангийн төсөл	Эрдэнэ	Эрдэнэ сумын ЗДТГ	Сумын ЗДТГ "Малжуулах сан"-тай болох
Сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах төсөл	Эрдэнэ	Эрдэнэ сумын ЗДТГ	Бүрдэний сувиллын газрын менежментийг сайжруулах
Сүү, сүүн бүтээгдэхүүн хамтран борлуулах төсөл	Эрдэнэ	Малчдын бүлэг	Сүү, сүүн бүтээгдэхүүнийг жил тойрон борлуулах тогтолцоотой болох
Хонины ноос боловсруулах, бүтээгдэхүүн борлуулах төсөл	3 сум	Иргэдийн бүлэг	Хөнгөлөлттэй хөрөнгө оруулалтын үр дүнд суманд боловсруулах жижиг үйлдвэр (хонины ноосны) байгуулагдана.
"Гар худгийн кампани" төсөл	3 сум	3 сумын ЗДТГ	Сумын захиргаа гар худгийн тоог олшруулах ажлыг дэмжих чадвартай болно.

* Тайлбар: 3 сум гэдэг нь Дорноговь аймгийн Эрдэнэ, Улаанбадрах, Хөвсгөл сумд болно.

(Туршилтын төслүүд ба хөгжүүлэх бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдаа холбоо)

Судалгаагаар боловсруулан гаргаж ирэх төлөвлөгөөний эцсийн үр дүн (зорилт) нь "Зудын хохирлыг багасгах, бэлчээрийн талхагдлыг арилгах"-ад чиглэгдсэн "Хөдөөгийн МАА-н тогтолцоог сайжруулах" явдал бөгөөд жижиг төслүүд тус бүр уг зорилтын аль бүтэц бүрэлдэхүүн хэсэгт хамаарч буйг доорх хүснэгтэд үзүүлэв.

"Мал эмнэлгийн үйлчилгээ сайжруулах" төслийн хувьд мэргэжлийн чанартай асуудал давамгайл, малчид болон иргэд өөрсдөө голлон хэрэгжүүлж ажиллахад бэрхшээлтэй талтайгаас төслийн санал гарч ирээгүй.

"Малжуулах сан" ба "сүүн бүтээгдэхүүний" төслүүдийн хувьд судалгаагаар

төлөвлөгөөг нь гарган ирж хэрэгжүүлэх зорилт бүхий ерөнхий төслөөс элементийг нь гарган ирж, хэсэгчилсэн байдлаар туршилтын төсөл болгон хэрэгжүүлсэн ба үр дүнг нь (нарийвчилсан) төлөвлөгөөнд тусгах (feedback)-ад учир дутагдалтай. Харин нөгөө талаас "бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын" бүрэлдэхүүн хэсэг нь хөдөөгийн МАА-н тогтолцоог сайжруулах төлөвлөгөөний чухал хэсэг тул бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын төсөл ба гар худгийн кампанит ажил өрнүүлэх төсөл гэсэн туршилтын судалгаагаар дараагийн төлөвлөгөөнд нарийвчлан тусгаж, нарийн тодорхой төлөвлөгөө боловсруулан гаргаж ирэх боломжтой болсон болно.

(Төсөл тус бүрийн агуулгыг "4.6 Туршилтын төслийн хэрэгжилтийн агуулга" гэсэн хэсгээс үзнэ үү.)

Бодлого чиглэл, эцсийн үр дүн	Хөгжүүлэх бүрэлдэхүүн хэсэг	Төслүүд	Тухайн бүрэлдэхүүн хэсэгт тохирох туршилтын төсөл	
Хөдөөгийн МАА-н тогтолцоог сайжруулах (Зудын хохирлыг багасгах, бэлчээрийн талхагдлыг арилгах)	Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежмент	Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежмент	Бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын төсөл ба гар худгийн кампани өрнүүлэх төсөл	
	МАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг сайжруулах	Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах		
		Шилмэл омог, үүлдрийн мал үржүүлэх	Малжуулах сан	
		Мал маллагааны арга, технологийг сайжруулах	Малжуулах сан	
		Эрсдэлийн менежментийн чадварыг дээшлүүлэх	Малжуулах сан	
	Малчин өрхийн орлогыг тогтворжуулах	МАА-н эрхлэлтийн менежментийг сайжруулах	Сүү, сүүн бүтээгдэхүүн борлуулах	
		МАА-н бүтээгдэхүүний зах зээл, ханган нийлүүлэлтийг сайжруулах	Сүү, сүүн бүтээгдэхүүн хамтран борлуулах	
Хүний нөөцийг хөгжүүлэх	-	Туршилтын төслүүдээр дамжуулан хүний нөөцийг сургаж бэлтгэх		

4.3 Туршилтын судалгааны хэрэгжилтийн үр дүнгээс олж авсан цаашдын төлөвлөгөөнд тусгууштай асуудлууд, тэдгээрийн нэгтгэн дүгнэлт

Хөдөөгийн МАА-н тогтолцоог сайжруулах төлөвлөгөөний чиг хандлага ямар байвал зохицыг туршин үзэж, илүү үр дүнтэй хойшдын ажлын чиглэлийг гаргаж ирэхийн тулд 6 туршилтын төсөл хэрэгжүүлээ. Эдгээр судалгааны төслүүдээр дамжуулан олж авсан мэдлэг туршлагыг доор нэгтгэн дүгнэж байна.

Туршилтын судалгаанаас цаашдын төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй хэмээн үзсэн асуудлууд

1. Үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төлөвлөгөө боловсруулах шаардлагатай.

- 1-1. Зохион байгуулалтад оруулах нь үр дүнтэй.
- 1-2. Үйл ажиллагааны үр шимийг хүртэгсдээр зардал хариуцуулах, сан байгуулах нь үр дүнтэй.
- 1-3. Хэт их хөрөнгө оруулахгүй байхад анхаарах шаардлагатай.

2. Дүрэм, журам боловсруулахад анхаарах зүйлс

- 2-1. Дүрэм, журам боловсруулсны ач холбогдол гарч байх ёстой.
- 2-2. Дүрэм, журам боловсруулсны ач холбогдол гарахгүй байвал яах вэ, - Говийн нөхцөл дэх бэлчээрийн менежментийн журам ямар байвал зохих -

3. Төслийн үр шимийг хүртэгчид болон засаг захиргаа (ялангуяа сумын ЗДТГ)-ны ажилтнуудыг сургах (хүний нөөцийн) сургалт

- 3-1. Засаг захиргааны ажилтнуудыг сургах
- 3-2. Төсөлд хамрагдагсдыг сургах
- 3-3. Малчдын бүлэг ба засаг захиргааны хооронд харилцан итгэлцэл бүхий харилцааг бий болгох (Сумын ЗДТГ-аас явуулах хяналт, мониторингийн тогтолцоог бий болгох)

(Үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төлөвлөгөө боловсруулах)

Малчид, иргэдийг зохион байгуулалтад оруулах нь үр дүнтэй :

Туршилтын судалгааны үр дүнд говийн бүсэд ч гэсэн малчдыг зохион байгуулалтад оруулж, бүлгийн үйл ажиллагааг тогтвортой өрнүүлж болох юм гэдгийг баталлаа. Мөн ийнхүү зохион байгуулалтад орсноор малчид ба иргэд дор дороо шийдвэрлэхэд бэрхшээлтэй асуудлуудыг бүлгийнхээ хэмжээнд өөрсдөө хэлэлцэж, хамтран шийдвэрлэж чадах юм байна гэдэг далд чадвараа нээн гаргаж чадсан. Цаашилбал төслийн зорьсон үр дүн, тавьсан зорилтод хүрэхийн тулд малчид, иргэдийг зохион байгуулалтад оруулан үйл ажиллагаа явуулах ажлын үр дүнтэй гэдэг нь нотлогдож байна.

Үйл ажиллагааны үр шимийг хүртэгсдээр зардал хариуцуулж, сан байгуулах нь үр дүнтэй :

Бүх бүлгүүдэд эрхэлж буй үйл ажиллагаандаа эзэн хүний ёсоор хандах ухамсрыг төлөвшүүлж, үйл ажиллагааны тогтвортой үргэлжлэх байдлыг хангах зорилгоор үр шимийг хүртэгсдээр зардал хариуцуулахаар болсон. Зардал хариуцах нь тэдэнд эдийн засгийн ачаалал учруулах хэдий ч бүх бүлгүүд үүнийг зөвшөөрөн хүлээж авсан юм. Хариуцах зардлын буцаан төлөлтийн процесс төлөвлөгөөний дагуу биш ч гэсэн бодитойгоор явагдаж байгаа ба үр дүнтэй болох нь нотлогдож байна.

Хэт их хөрөнгө оруулалт хийхгүй байхад анхаарах шаардлагатай :

Үр шимийг хүртэгчдээд зардал хариуцуулахын хамтаар эхний удаагийн хөрөнгө оруулалтыг нэг удаа бөөнд нь хийж орхих юм бол (төсөлд) оролцогч энэ ачааллыг давж гарч чадахгүй байдалд орох магадлалтай. Иймээс эхний

удаагийн хөрөнгө оруулалтын хэмжээг аль болох бага байлгаж, бүлгийн үйл ажиллагаа гольдролдоо орж, тодорхой хэмжээний туршлагатай болсон үед нь тэдний өөрсдийнх нь шийдвэрт үндэслэн шаардлагатай нэмэлт хөрөнгө оруулалтыг хийх нь зүйтэй.

(Дүрэм, журам боловсруулахад анхаарах зүйлс)

Ач холбогдолтой дүрэм, журам :

Малжуулах сан, сумын худгийн сангуудын хувьд дүрэм боловсруулан ашигласан нь ихээхэн ач холбогдлоо өгсөн. Зардал төлөгч талын хувьд сан зөв зохистой хяналтын доор ашигтай зарцуулагдаж чадахгүй байвал зардал буцаан төлөх сонирхлыг нь бууруулах болно. Иймд тодорхой журмын дагуу, тодорхой шийдвэр гарган, сангийн үйл ажиллагааг явуулах нь түүний бүрэлдэн тогтноход зайлшгүй чухал юм.

Туршилтын судалгааны хүрээнд үйл ажиллагаа явуулах бүлэг ба сумын ЗДТГ-ын хооронд гэрээ байгуулан гэрээгээр хүлээх тус тусын хариуцлага ба ажил үүргийн хуваарь, хариуцах зардлын хэмжээг тодорхой тусгасан. Энэхүү гэрээ нь эрх зүйн байр суурь тодорхойгүй малчдын бүлгийн хувьд цорын ганц тэднийг тодорхойлох зүйл болж байгаа ба зохион байгуулалтаа үргэлжлүүлэн авч явах тал дээр нь ч чухал үүрэгтэй.

Ач холбогдолгүй журам –Говийн нөхцөл дэх бэлчээр ашиглалтын журам- :

Говийн бүс нутгийн малчид бэлчээрийг уламжлалт аргаараа ашиглан, муутгахгүй байхад анхаарахын хамтаар илүү сайн бэлчээрийг эрэлхийлэн нүүдэл хийж явдаг. Ийм орчинд худаг орчмын бэлчээрт бичгээр боловсруулсан журам боловсруулан мөрдүүлж үзэхээр туршсан боловч малчид түүний ач холбогдол, шаардлагыг ойлгохгүй байгаа тул бэлчээр ашиглалтыг журмыг бичгээр боловсруулах нь бодитоор хэрэгжих магадлал үгүй байна.

(Үр шимийг хүртэгчид болон засаг захиргаа (ялангуяа сумын ЗДТГ)-ны ажилтнуудыг сургах хүний нөөцийн сургалт)

Захиргааны ажилтнуудын сургалт :

Хөдөөгийн МАА-н тогтолцоог сайжруулах төлөвлөгөө нь ихээхэн олон талыг хамарч буй. Иймд энэхүү олон талт үйл ажиллагаанд оролцох захиргааны ажилтнуудыг сургаж бэлтгэх явдал зайлшгүй чухал. Ялангуяа биечлэн оролцох хэлбэр (төсөлд хамрагдагсад түүний бүх үе шатанд биечлэн оролцох)-ийг хөгжүүлэхэд шаардлагатай арга зам, хүмүүсийг зохион байгуулалтад оруулах арга замын талаарх чадварыг тэдэнд төлөвшүүлэх шаардлагатай.

Үр шимийг хүртэгчид (малчид, иргэд)-ийн хүний нөөцийн сургалт :

Малчид, иргэдийг зохион байгуулалтад оруулан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд зохион байгуулалтад оруулах төдийгөөр тогтвортой үйл ажиллагаа